



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

“Ажлын байрны ашиглалтын зааварчилгаа” батлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ажлын байрны онцлогт нийцсэн “Тоног төхөөрөмжийн засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 1 дүгээр хавсралтаар, “Тоноглолын ашиглалтын болон засварын ажилтны аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа”-г 2 дугаар хавсралтаар, “Наряд олгогч, ажлын удирдагч, эзлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 3 дугаар хавсралтаар, “Гал тогооны ажилтны ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 4 дүгээр хавсралтаар, “Өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 5 дугаар хавсралтаар, “Цахилгаанчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 6 дугаар хавсралтаар, “Оосорлогч-дохиочны аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 7 дугаар “Бага температурт задгай талбайд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г 8 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан зааварчилгааг үйл ажиллагаанд мөрдүүлж ажиллахыг Үйлдвэрлэлийн албаны дарга, Ерөнхий инженер, Ерөнхий механик, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэгт тус тус үүрэг болгосугай.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М. ГАНБААТАР

	Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02	БАТБАЯ Гүйцэтгэх захирал / М.Танбаатар
		Хувилбар: 1 Тушаал № 1/42	

НАРЯД ОЛГОГЧ, АЖЛЫН УДИРДАГЧ, ЭЭЛЖИЙН АХЛАХ АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

	Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02	БАТЛАВ Гүйцэтгэх захирал /...../ М. Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2020 онсар өдөр
		Тушаал №	

НАРЯД ОЛГОГЧ, АЖЛЫН УДИРДАГЧ, ЭЭЛЖИЙН АХЛАХ АЖИЛТНЫ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	М.Анхныбаяр	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Э.Амарсайхан	ХАБЭА-н ажилтан	

Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	4
Хоёр. Үүрэг, хариуцлага.....	4
Гурав. Ажил эхлэхийн өмнөх аюулгүйн шаардлага.....	5
Дөрөв. Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны заавар.....	6
Тав. Ажил дууссаны дараах аюулгүйн шаардлага	6

Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02
	Хувилбар: 1

НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

- 1.1. Наряд олгогч, ажлын удирдагч, ээлжийн ахлах ажилтан нь ажлыг аюулгүй гүйцэтгэх арга аргачлалд суралцсан, ажлын байранд дадлага хийсэн, ажлын байрны тодорхойлолтын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон цахилгааны аюулгүй байдал, галын аюулгүй байдлын дүрмийн шалгалт өгч, зөвшөөрөл авсан, осолдогчид үзүүлэх анхан шатны тусламж үзүүлэх сургалтанд хамрагдсан байх.
- 1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн давтан зааварчилгаанд 6 сард нэгээс доошгүй удаа хамрагдаж, шалгалт өгч тэнцсэн байна.
- 1.3. Наряд олгогч, ажлын удирдагч, ээлжийн ахлах ажилтан нь ажил гүйцэтгэгчээс ялгарах дуулга, ажлын тусгай хувцас зэрэг хувийн хамгаалах хэрэгслээр хангагдсан байна. Дуулганы өнгө ажлын байрны тодорхойлолтын дагуу гүйцэтгэх ажил үүргийн онцлогоор хоорондоо ялгаатай байж болно.

ХОЁР. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 2.1. Наряд олгогч, ажлын удирдагч, ээлжийн ахлах ажилтан нь шууд харъяалах албан тушаалтнуудад өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, ажил үүргийг хуваарилах бөгөөд технологийн процесс болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандарт норм, дүрэм журам, заавар зааварчилгаа өөрчлөгдсөн, үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал өөрчлөгдсөн, шинэчлэлт, сайжруулалт хийгдсэн, хөдөлмөрийн нөхцөл, зохион байгуулалт өөрчлөгдсөн болон осол, гэмтэл, аюултай тохиолдол бүрд, мөн календарын 30 ба түүнээс дээш хоногоор (хөдөлмөрийн аюултай, хортой, хүнд нөхцөлд ажилладаг бол 15 ба түүнээс дээш хоногоор) ажил завсарласан зэрэг тохиолдолд өөрт шууд харъяалагдах албан тушаалтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит бус давтан зааварчилгаа өгөх үүрэгтэй.
- 2.2. Компанийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, заавар зааварчилгааг мөрдөх, өөрийн шууд харъялах албан тушаалтны аюулгүй ажиллагаа мөрдөлтөнд хяналт тавих, мөрдүүлэх шаардлага тавих үүрэгтэй.
- 2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилсан зааварчилгаа, ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа авч, шалгалт өгч тэнцээгүй иргэнээр ажил гүйцэтгүүлэхгүй байх. Ажлын байранд дадлага хийгээгүй ажилтнаар бие даан ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх.
- 2.4. Тоног төхөөрөмжийг ашиглах ажлын аюулгүй шаардлага, зааврыг мөрдөх.
- 2.5. Өөрийн хариуцах хэсэг нэгжийн гүйцэтгэх ажлыг удирдан зохион байгуулах. Шууд харъяалагдах албан тушаалтны аюулгүй ажиллагааг бүрэн хангах.

Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02
	Хувилбар: 1

- 2.6. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тоноглолын бүтэц, схем, техникийн тодорхойлолт, зохион байгуулалт, онцлог ашиглалтын горимыг мэддэг байх, аюулгүй ажиллагааны зааварыг мөрдөх, осол аваари, тоног төхөөрөмжийн гэмтлийн үед аваарийн зогсолт хийх, аюулгүй ажиллагааг зохион байгуулах, манлайлах.
- 2.7. Тоног төхөөрөмжийн паспорт, арга зүйн баримт бичигт хөтлөлт, бүрдүүлэлт, бүртгэл, архивлах ажлыг гүйцэтгэх.
- 2.8. Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэлийн бүтэц, онцлог ажиллагааг мэдэх ашиглаж чаддаг байх.
- 2.9. Ээлжийн ахлах ажлын үед дараах аюултай болон хортой хүчин зүйлсийг арилгаж чаддаг байна:
- ❖ Өндрөөс унаж болох багаж хэрэгсэл, бараа материал, эд зүйлс.
 - ❖ Хөдөлгөөнт техник хэрэгсэл (автокран, манипуляторт кран, дугуйт ачигч, сэрээт өргөгч, авто самосвал г.м.)-ийн хөдөлгөөн.
 - ❖ Хаалт хашилтгүй эргэлдэх механизмд ажилтний эд эрхтэн, хувцас, ажлын багаж хэрэгсэл орооцолдох, хавчуулагдах.
 - ❖ Өргөх зөөх ажиллагаанд өргөсөн ачаа унах, савах болон өндөр хураасан бараа материал нурах.
 - ❖ Хүн бүдрэх, халтрах, өндрөөс унах нөхцөл байдал.
 - ❖ Ажилтнууд аюулгүй ажиллагааны дүрэм, шаардлага, зааварчилгаа зөрчиж ажиллах
 - ❖ Гал гарах нөхцөл бүрдэх.
- 2.10. Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох тохиолдол бүрийг шууд удирдлага болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэсэгт мэдээлэх.
- 2.11. Энэхүү зааварчилгааг мөрдөөгүй, зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГУРАВ. АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 3.1. Өөрийн шууд харъяалах албан тушаалтнуудыг бүртгэж, ажилтан бүр ажил гүйцэтгэх бүрэн чадвартай эсэх, тэднийг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангах, тэдгээрийн хэвийн, бүрэн бүтэн байдал, зөв хэрэглээг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулна.
- 3.2. Ажлын гүйцэтгэлийн дарааллыг тогтооно.
- 3.3. Ажилтнуудын ээлж хүлээлцэхэд хяналт тавих. Арга зүйн зөвөлгөө өгөх.
- 3.4. Ажил гүйцэтгэх шаардлагатай хамтын хамгаалах хэрэгсэл (хаалт, хашилт, тусгаарлалт, цоож пайз) бүрэн бүтэн, хэвийн ажиллагаатай байгаа эсэхэд,

Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02
	Хувилбар: 1

ажилтнууд түүний талаар мэдлэг ойлголттой, зөв хэрэглэж чаддаг эсэхийг шалгаж, заавар зөвөлгөө өгөх.

- 3.5. Ажлын байр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж, шаардлага хангуулах. (агааржуулалт, гэрэлтүүлэг, агаарын температур г.м.)
- 3.6. Өөрийн шууд харъяалагдах албан тушаалтнууд ажлыг аюулгүй гүйцэтгэх бүрэн боломжтой ирц бүрдсэн үед өмнөх ээлжийн ахлах ажилтнаас ажлын байрыг хүлээж авна.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

- 4.1. Өөрийн өгсөн наряд, үүрэг даалгаврын биелэлт, гүйцэтгэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, зааварчилгааны мөрдөлт, хувийн хамгаалах хэрэгслийн зөв хэрэглээнд хяналт тавих.
- 4.2. Аюулгүй ажиллагаа зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоож, бүртгэх, мэдээлэх, засаж залруулах арга хэмжээг зохион байгуулах.
- 4.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол бүрийг бүртгэж, мэдээлэх, дахин давдагдан гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, оролцох.
- 4.4. Гамшиг ослын үед гамшигийн үеийн төлөвлөгөөний дагуу өөрийн шууд харъяалагдах албан тушаалтнуудыг ажлын байрыг чөлөөлүүлж, цугларах цэгт цуглуулж бүртгэх, шаардлагатай осолдогчид аврах ажиллагаа зохион байгуулах, анхны тусламж үзүүлэх.
- 4.5. Биеийн байдал муудсан, тавгүйрэхсэн тохиолдолд болон шаардлагатай үед өөрийн ажил үүргийг орлон гүйцэтгэгийг урьдчилан томилсон байна.

ТАВ. АЖИЛ ДУУССАНЫ ДАРААХ АЮУЛГҮЙН ШААРДЛАГА

- 5.1. Эргэх механизм, түүний орчинд цэвэрлэгээ хийхдээ төхөөрөмжийг заавал зогсооно.
- 5.2. Өөрийн шууд удирдлагад харъяалагдах албан тушаалтнуудын ажлын байрны цэвэрлээг, эмх цэгц, аюулгүй байдлыг хангаж дараагийн ээлжийн ахлах ажилтанд ажлын байрыг хүлээлгэн өгнө.
- 5.3. Өөрийн ажилласан ээлжинд гарсан осол аваарь, тоног төхөөрөмжийн гэмтэл, аюултай тохиолдол болон хийгдсэн засвар үйлчилгээ, шуурхай ажиллагаа бүрийн талаар үнэн бодит мэдээллийг дараагийн ээлжийн ахлах ажилтанд өгөх үүрэгтэй.
- 5.4. Дараагийн ээлжийн ажил гүйцэтгэх багийн ажлыг аюулгүй гүйцэтгэх боломжтой ирц бүрдсэн тохиолдолд ажлын байр, шаардлагатай баримт бичиг, багаж хэрэгслийг дараагийн ээлжийн ахлах ажилтанд хүлээлгэн өгнө.

Наряд олгогч, ажил удирдагч, ээлжийн ахлах ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгаа	ТТТ-ТЕ-02
	Хувилбар: 1

- 5.5. Ээлж хүлээлгэн өгсний дараа өөрт шууд харъяалагдах албан тушаалтнуудад ажлын байрыг орхих зөвшөөрөл олгоно.
- 5.6. Ажилласан ээлжинд хийж гүйцэтгэсэн ажил, доголдол гарсан, авч хэрэгжүүлсэн шуурхай арга хэмжээний тухай шууд удирдлагадаа мэдээлнэ.